



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.АЛТАНХУЯГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

ддз. 12. 19 № 105/ д.Б.96
танай _____-ны № _____-т


Асуулгын хариу хүргүүлэх тухай

Төсвийн тогтвортой байдлын тухай болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Сангийн сайд болон “Эрдэнэс тавантолгой” ХК-аас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт ¹⁰ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000235027350



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.12.04 № 01/8840
танай _____-ны № ХЭГ/2566 -Т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн ХЭГ/2566 тоот Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу бэлтгэн ирүүлэх тухай албан бичигтэй танилцлаа.

Үүнтэй холбогдуулан тус яамны чиг үүргийн хүрээнд хамаарах асуудлаар асуулгын хариуг бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Харин асуулгын 2.12-т тусгагдсан асуудлыг холбогдох байгууллагаас гаргуулна уу.

Хавсралт 2 хуудастай.

Хувийг: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9762004816

Сангийн сайдын 2023 оны 12-р сарын 04-ны өдрийн

01/8840..... тоотын хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.АЛТАНХУЯГААС ЕРӨНХИЙ
САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

1.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг хангагдсан тохиолдолд Төсвийн тогтворжуулалтын сангаас зарлага гарах эрх зүйн зохицуулалттай. Иймд тус сангаас гарсан зарлагууд нь дээрх хуулийн шаардлагыг хангасан эсэх талаар болон хуульд заасан шаардлагаа хангаагүй зарлага байгаа эсэх талаар:

Хариулт: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт “Төсвийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна” гэж заасан. Түүнчлэн, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4 дэх заалтад тус сангийн хөрөнгөөс тухайн жилийн төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар улсын төсөвт шилжүүлэхээр хуульчилсан байдаг.

Дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд тухайн жилийн төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар Төсвийн тогтворжуулалтын сангаас 2014, 2017, 2019, 2020, 2021, 2022 онуудад улсын төсөвт нийт 2,631.6 тэрбум төгрөгийн шилжүүлэг хийгдсэн. Харин бусад зориулалтаар тус сангаас зарцуулалт гараагүй бөгөөд сангийн мөнгөн хөрөнгийг зохистой удирдаж авлага, өглөг үүсгэлгүй ирсэн болно. Өнгөрсөн хугацаанд Төсвийн тогтворжуулалтын сангийн үндсэн зорилго болох төсвийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангах буюу эрдэс баялгийн үнийн хэлбэлзлээс хамаарсан төсвийн орлогын өсөлт, бууралтыг тогтворжуулах хүрээнд үүргээ гүйцэтгэж ирсэн болно.

1.2. Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого, зарлага, үлдэгдлийн дэлгэрэнгүй мэдээ /тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 11 сар
НИЙТ ОРЛОГО	241.0	94.7	46.9	40.5	5.5	10.1	345.6	197.8	106.3	52.4	728.8	1,415.0	621.6
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	84.9	23.1	7.6				28.3	69.2	40.4	5.0	166.9	238.2	92.8
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	156.1	64.3	39.3	39.9	2.3		297.4	128.4	60.2	47.4	561.8	1,176.7	528.8
Засгийн газрын нөөц хөрөнгийн үлдэгдэл		2.3		0.6			5.3	0.2	5.6				
Эрсдэлийн сангийн үлдэгдэл		5.0											

Бусад					3.2	10.1	14.6						
Улсын төсөвт шилжүүлэг				118.2			572.1		322.0	138.8	728.8	751.7	
ТУХАЙН ОНЫ ХУРИМТЛАЛ	241.0	335.7	383.5	307.3	314.5	332.0	104.2	302.0	86.4	0.0	0.0	663.3	1,284.9

1.3. Алт, зэс, нүүрс, төмрийн хүдрийн дэлхийн зах зээлийн үнийн динамик, борлуулалтын орлогын динамикийг ашигт малтмал тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлэх

		Алт	Мөнгө	Зэс*	Нүүрс*		Төмрийн хүдэр /56 хувийн агуулга/	Төмрийн баяжмал /60 хувийн агуулга/
					Баяжуулсан коксжих	Боловсруулаагүй коксжих		
Хэмжих нэгж		ам.дол/унц		ам.дол/тонн				
Эх сурвалж он, сар		mongolbank.mn		lme.com	sxcoal.com		custeel.net	
2016	1	1,091.4	11.0	4,462.3	54.6	34.2	30.4	34.0
2016	2	1,190.9	12.0	4,595.0	54.9	34.4	35.8	37.9
2016	3	1,239.5	12.4	4,947.0	55.5	34.6	45.0	47.1
2016	4	1,238.0	13.1	4,850.6	56.1	34.7	47.8	50.5
2016	5	1,259.7	14.0	4,707.9	56.4	38.6	44.1	45.2
2016	6	1,269.5	14.1	4,630.3	59.0	41.0	41.9	41.7
2016	7	1,327.1	16.7	4,855.4	58.3	51.3	45.4	46.0
2016	8	1,334.4	16.6	4,757.8	72.0	55.6	47.6	50.4
2016	9	1,320.6	16.2	4,706.8	73.4	64.7	42.3	45.8
2016	10	1,264.4	15.4	4,731.8	103.5	104.1	43.8	46.8
2016	11	1,238.2	15.5	5,442.7	134.7	125.0	55.4	59.4
2016	12	1,149.2	15.4	5,665.8	146.1	135.9	61.7	62.3
2017	1	1,188.7	16.7	5,737.0	141.3	127.7	63.1	72.5
2017	2	1,229.3	17.8	5,941.1	139.8	113.9	68.5	79.2
2017	3	1,231.7	17.6	5,821.1	138.0	106.0	63.8	78.6
2017	4	1,267.1	18.2	5,697.4	142.6	112.0	44.8	61.7
2017	5	1,247.3	16.8	5,591.1	140.2	117.9	38.4	53.4
2017	6	1,261.6	17.0	5,699.1	136.9	108.2	32.8	48.6
2017	7	1,238.6	16.2	5,978.1	139.5	107.4	41.2	58.3
2017	8	1,280.5	16.9	6,477.7	148.0	115.3	47.8	66.6
2017	9	1,315.4	17.5	6,582.7	158.5	130.2	42.2	61.4
2017	10	1,282.1	17.0	6,796.9	154.3	129.0	35.0	51.5
2017	11	1,282.1	17.0	6,825.1	126.0	123.5	36.3	54.7
2017	12	1,261.6	16.1	6,800.6	121.8	130.0	40.7	61.4
2018	1	1,327.5	15.2	7,079.9	125.0	139.6	45.3	65.3
2018	2	1,330.5	14.7	7,001.3	127.1	142.0	47.4	67.5
2018	3	1,322.1	14.5	6,795.3	150.0	142.0	41.0	61.0
2018	4	1,331.8.	14.6	6,838.1	143.5	138.1	38.0	56.9

2018	5	1,301.5	14.5	6,821.3	142.2	130.1	36.9	56.3
2018	6	1,279.6	14.5	6,954.2	144.1	128.2	35.2	54.8
2018	7	1,269.8	14.1	6,247.6	136.3	123.4	33.9	53.5
2018	8	1,199.7	13.0	6,039.3	125.3	121.0	35.2	56.1
2018	9	1,195.3	12.3	6,019.6	133.4	123.2	36.4	58.2
2018	10	1,211.9	12.6	6,215.2	134.2	122.3	39.6	62.6
2018	11	1,216.7	12.3	6,192.4	147.0	123.9	41.2	63.0
2018	12	1,245.6	13.0	6,093.5	139.6	124.8	40.1	59.4
2019	1	1,288.1	14.6	5,931.6	137.9	128.2	47.6	67.2
2019	2	1,319.9	14.8	6,277.8	136.8	130.2	58.8	78.4
2019	3	1,301.0	14.4	6,450.3	140.1	134.9	62.7	79.8
2019	4	1,283.8	14.0	6,444.5	140.1	131.5	71.9	86.2
2019	5	1,280.9	13.6	6,027.7	137.4	127.0	64.3	88.9
2019	6	1,351.2	14.0	5,868.0	135.9	127.2	84.2	97.1
2019	7	1,410.3	14.8	5,939.2	132.6	126.4	92.9	107.0
2019	8	1,492.3	16.0	5,707.6	131.1	123.5	64.6	80.0
2019	9	1,511.4	17.2	5,745.0	130.1	119.7	63.8	78.8
2019	10	1,490.9	16.6	5,742.4	127.8	114.3	65.7	76.9
2019	11	1,471.7	16.3	5,859.3	115.7	110.1	62.7	72.8
2019	12	1,473.7	16.1	6,062.1	114.5	106.9	66.9	79.0
2020	1	1,555.1	17.0	6,048.7	121.8	109.9	71.1	83.6
2020	2	1,583.0	16.8	5,685.9	124.7	110.6	66.1	77.0
2020	3	1,589.6	14.1	5,178.4	126.6	117.3	70.3	79.8
2020	4	1,676.2	14.0	5,048.3	117.5	114.2	65.1	75.5
2020	5	1,712.9	15.1	5,233.8	115.8	106.3	73.0	84.5
2020	6	1,727.5	16.7	5,742.4	118.2	104.0	81.3	92.1
2020	7	1,836.8	19.3	6,353.8	118.2	106.0	83.5	94.6
2020	8	1,966.1	25.8	6,496.7	119.2	106.3	96.5	109.7
2020	9	1,923.4	25.1	6,712.4	124.6	106.5	96.3	112.1
2020	10	1,898.1	23.3	6,702.8	128.4	108.7	91.3	107.6
2020	11	1,864.1	23.1	7,063.4	127.7	115.1	96.6	112.7
2020	12	1,850.4	23.7	7,755.2	134.7	131.2	126.7	143.3
2021	1	1,866.2	24.9	7,970.5	153.9	150.9	136.0	154.8
2021	2	1,810.9	26.4	8,460.3	158.2	158.7	131.6	155.5
2021	3	1,719.6	24.7	9,005.0	141.6	147.2	132.9	153.8
2021	4	1,753.0	24.4	9,335.6	197.8	162.1	142.2	163.1
2021	5	1,841.0	26.3	10,184.0	231.4	193.7	163.6	187.7
2021	6	1,833.2	26.0	9,612.4	239.8	207.1	169.3	195.2
2021	7	1,799.9	24.6	9,433.6	263.7	217.3	162.7	195.4
2021	8	1,783.1	23.1	9,357.2	323.9	268.4	108.8	141.3
2021	9	1,778.5	22.4	9,323.7	466.3	408.5	77.9	102.4
2021	10	1,773.6	22.2	9,777.4	473.3	404.4	74.3	101.8
2021	11	1,819.3	23.3	9,764.6	330.2	252.6	56.2	80.6
2021	12	1,787.1	21.5	9,549.1	278.8	232.8	73.6	98.0
2022	1	1,814.7	22.2	9,774.5	329.3	275.3	97.6	119.3

2022	2	1,857.2	22.5	9,940.0	327.5	284.8	109.7	128.7
2022	3	1,940.3	24.2	10,236.7	392.3	323.0	109.4	133.6
2022	4	1,932.0	23.7	10,182.3	408.2	344.2	93.0	136.4
2022	5	1,931.2	21.0	9,362.1	346.7	271.4	77.5	115.1
2022	6	1,945.5	20.8	9,032.0	346.7	274.8	85.5	114.2
2022	7	1,827.2	18.1	7,529.1	280.3	226.0	75.2	93.5
2022	8	1,852.1	18.8	7,960.2	243.2	199.3	73.4	93.7
2022	9	1,762.5	17.8	7,733.8	240.4	195.2	68.3	86.3
2022	10	1,746.1	18.3	7,620.3	258.6	207.3	68.2	81.6
2022	11	1,803.7	19.9	8,028.9	235.9	193.8	67.9	81.1
2022	12	1,882.1	22.1	8,366.8	252.9	203.5	78.3	98.2
2023	1	1,886.6	22.8	8,999.3	251.6	195.8	89.2	111.9
2023	2	1,860.0	21.2	8,954.4	250.4	204.0	93.3	115.6
2023	3	1,907.7	20.8	8,834.7	267.4	213.5	96.4	114.6
2023	4	1,999.7	24.0	8,813.4	218.8	174.5	87.8	104.7
2023	5	1,988.1	23.3	8,233.6	185.0	150.4	76.8	92.0
2023	6	1,942.8	22.5	8,385.6	171.6	135.6	81.6	100.6
2023	7	1,945.8	23.2	8,444.6	184.7	148.3	83.7	101.3
2023	8	1,918.6	22.5	8,351.2	202.5	161.5	79.7	97.4
2023	9	1,918.7	22.3	8,270.2	196.7	176.6	88.6	108.2
2023	10	1,905.5	21.3	7,939.2	215.7	187.9	91.5	105.0

1.4. Төсвийн тогтворжуулалтын сангаас АМНАТ болон бусад орлого, хүүгийн орлого, улсын төсөвт шилжүүлгийн зарлагын талаарх мэдээлэл

Хариулт: Дээр дурдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого, зарлага, тайлагнал болон гүйцэтгэлд хяналт тавихтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулж ирсэн. Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад “гол нэр төрлийн эрдэс баялаг” гэж тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялаг байна гэж тодорхойлсон байдаг. Тус заалтын дагуу нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлэгч буюу зэс, нүүрсний орлогоос Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилдаг болно. Харин зарцуулалтын хувьд дээр дурдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4 дэх заалтад заасны дагуу тухайн жилийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2014, 2017, 2019-2022 онуудад улсын төсөвт шилжүүлэг хийгдсэн болно.

2. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

2.1. Ирээдүйн өв сангийн тухай хуульд заасан сангийн хөрөнгийн удирдлага, эх үүсвэр, зарцуулалттай холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн талаар

Хариулт: Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Сан Монгол Улсын нийт ард түмний өмч байна” гэж заасан тул сангийн

хөрөнгийг найдвартай, эрсдэлгүй байх зарчмыг баримтлан сангийн хөрөнгийг удирдах чиглэлээр ажиллаж ирсэн. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмыг тухай хуульд 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр нэмэлт орж, 5¹ дүгээр зүйлд “Корпораци бие даан тогтвортой үйл ажиллагаа явуулах бүтэц, чадамжтай болох хүртэл сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.” гэсэн агуулга бүхий зүйл нэмсэн. Хуулийн энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд Сангийн яамнаас сангийн хөрөнгийг аль болох эрсдэлд оруулахгүй байх, гадаад санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан үзэх, дотоодын валютын ханшийн болзошгүй хэлбэлзлээс урьдчилан сэргийлэх зэрэг хөрөнгийн удирдлагын арга хэмжээг авч ажилласан ба Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой дээр дурдсан 5¹ дүгээр зүйлд өөрчлөлт орж, “... төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах, мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хуримтлуулна.” гэж заасан.

2.2. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Сангийн хөрөнгийн удирдлагыг энэ хуулийн дагуу байгуулагдах Корпораци хэрэгжүүлнэ.” гэх заалтын болон Засгийн газрын 2019 оны 303 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл

Хариулт: Засгийн газрын 2019 оны 303 дугаар тогтоолын 3 дугаар заалтад “Ирээдүйн өв сан корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг эхлүүлэх үеийн тохирсон бүтцийг бий болгох болон Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг хариуцуулах, зардлын хязгаарыг тогтоох асуудлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахыг Сангийн сайдад даалгасан. Мөн дээр дурдсан Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр орсон нэмэлттэй холбогдуулан Сангийн яамнаас хөрөнгийн удирдлагын чиглэлээр зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Харин Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Сангийн хөрөнгийн удирдлагыг энэ хуулийн дагуу байгуулагдах Корпораци хэрэгжүүлнэ.” гэж заасан ба тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5² дугаар зүйлд Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэхээр тогтоосон.

2.3. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Сангийн хөрөнгийн удирдлагыг мандатад заасны дагуу хэрэгжүүлнэ.” гэж заасан. Иймд Сангийн сайдын баталсан Хөрөнгийн удирдлагыг мандатад нийцүүлж хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаарх мэдээлэл

Хариулт: Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтад заасны дагуу “Хөрөнгийн удирдлагын мандат”-ыг Сангийн сайдын 2020 оны 10 дугаар тушаалаар баталсан. Өмнө дурдсан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн бөгөөд Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2.4. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн Сангийн хөрөнгийг удирдахад баримтлах зарчим буюу “Сан хараат бус байх”, “Сан ил тод байх”, “Сангийн хөрөнгийг зохистой удирдах”, “Сангийн хөрөнгийг үр ашигтай удирдах”, “Сангийн хөрөнгийн удирдлагын талаар үнэн зөв мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй мэдээлж байх” гэсэн заалтуудын хэрэгжилтийн талаарх мэдээлэл

Хариулт: Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад Сангийн хөрөнгийг удирдахад хараат бус байх зарчмыг баримтлахаар заасан бөгөөд мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт энэ хуулийн 5.1.1-д заасан хараат бус байх зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгайлан хуульчилсан. Энэхүү зохицуулалтын хүрээнд хуульд заасан зөвлөх баг, Удирдах зөвлөл, Нэр дэвшүүлэх хороо, Хяналтын зөвлөл гэх мэт сангийн үйл ажиллагаанд оролцогч этгээдүүд үйл ажиллагаандаа хараат бус байх зарчмыг мөрдөж ажиллах юм. Түүнчлэн дээрх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад сангийн хөрөнгийг удирдахад ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхээр, уг зарчмыг хэрэгжүүлэх арга замыг мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дэх хэсэгт тогтоосон. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх хүрээнд төрөөс мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор хөтөлж буй шилэн данс цахим хаягаар дамжуулан Ирээдүйн өв сангийн төсвийн гүйцэтгэлийг сар бүр, сангийн санхүүгийн тайланг хагас жилээр гарган, байршуулж олон нийтэд мэдээллийг ил тод хүргэж байна. Мөн хуулийн 5.1.3, 5.1.4 дэх заалтад заасан Сангийн хөрөнгийг зохистой, үр ашигтай удирдах зарчмуудыг Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2.5. 2017-2020 оны хооронд Ирээдүйн өв сан нь зөвхөн хуримтлал бий болгох хуулийн зохицуулалттай байсныг хэзээ, хэний саналаар зарлага гаргахаар өөрчилсөн талаар

Хариулт: Ирээдүйн өв сан нь Хүний хөгжил сангийн үргэлжлэл байдлаар байгуулагдсан ба тус сангийн 2017-2020 оны хооронд төвлөрүүлэх орлогоос Хүний хөгжил сангийн урьдын өрийг төлж барагдуулахад болон Хүний хөгжил сангийн зарлагуудыг аажмаар улсын төсөвт шилжүүлэхэд зориулагдсан. Энэхүү шилжилтийн үеийн зохицуулалтууд Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тодорхой тусгагдсан болно. Түүнчлэн, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуульд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр тус тус өөрчлөлт оруулж, Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд мөнгөн хуримтлал үүсгэж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд сар бүр 100.0 мянган төгрөг олгохоор шийдвэрлэсэн. Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, өрхийн орлогыг дэмжих зорилгоор Ирээдүйн өв сангийн тухай хуульд зөвхөн 2022 оны төсвийн жилд үйлчлэх зохицуулалттай хүүхдийн мөнгөн хуримтлалд зориулж санхүүжилт гаргасан.

2.6. Ирээдүйн өв сангийн орлогын гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 11 сар
НИЙТ ОРЛОГО	357.7	609.7	953.0	875.7	1151.7	1540.3	290.9
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	357.7	577.6	800.3	715.5	916.9	1054.5	90.2
Ногдол ашиг		32.1	152.7	160.2	204.8	450.8	200.7
Бусад					30.0	35.0	

2.7. Ирээдүйн өв сангийн зарлагын гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/

Ирээдүйн өв сангийн тухай хууль нь 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд тус сан нь Хүний хөгжил санд хуримтлагдсан өр болөх нийт 1,071.9 тэрбум төгрөгийг 2017-2019 онуудад үе шаттайгаар төлж барагдуулсан. Ингэснээр Ирээдүйн өв сан бодит хуримтлалтай болж эхэлсэн.

ҮЗҮҮЛЭЛТ	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 11 сар
НИЙТ ЗАРЛАГА	356.9	508.7	516.3			1488.1	
Хүүхдийн мөнгөн хуримтлал						1488.1	
Улсын төсөвт шилжүүлэг	160.0	100.0	50.0				
Хүний хөгжил сангаас шилжин ирсэн өглөгийг барагдуулсан	196.9	408.7	466.3				

2.8. Ирээдүйн өв санд төвлөрсөн үлдэгдэл мөнгөнөөс ханшийн зөрүүнээс алдагдал хүлээсэн эсэх болон хүлээсэн бол хэдэн төгрөгийн алдагдал хүлээсэн талаар

Хариулт: Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тус сангийн гол орлогын эх үүсвэр болох ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь нь үндэсний мөнгөн тэмдэгт буюу төгрөгөөр тухайн аж ахуй нэгж, хуулийн этгээд төсөвт төвлөрүүлдэг бөгөөд бүртгэл, тайлагналыг холбогдох журмын дагуу хөтөлж байна. Сангийн мөнгөн хөрөнгө төгрөгөөр хуримтлагдаж байгаа тул ханшийн аливаа эрсдэл үүсээгүй болно.

2.9. Ирээдүйн өв санд хуримтлагдсан орлогоос 2017-2023 онд гаргасан зарлагын талаар

Хариулт: Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуульд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр тус тус өөрчлөлт оруулж, Ирээдүйн өв санд 2022 онд

төвлөрсөн орлогоос Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд мөнгөн хуримтлал үүсгэхээр шийдвэрлэсэн. Үүнтэй холбогдуулан Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдаж, 2022 оны төсвийн жилд хүүхдийн хуримтлал үүсгэхэд шаардагдах хөрөнгийг 1,461.8 тэрбум төгрөгөөр баталсан. Хууль тогтоомжийн хүрээнд шаардлагатай санхүүжилтийг гаргасан болно.

2.10. Ирээдүйн өв сангийн үлдэгдэл /тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 11 сар
ТУХАЙН ОНЫ ХУРИМТЛАЛ	0.9	101.8	538.6	1414.2	2565.9	2618.1	2909.0

2.11. Хүний хөгжил сангаас 2017-2019 оны хугацаанд шилжиж ирсэн хэчнээн төгрөгийн өглөгийг хэрхэн барагдуулсан талаар

Хариулт: Өмнө дурдсан Хүний хөгжил сангаас шилжиж ирсэн нийт 1,071.9 тэрбум төгрөгийн өр, төлбөрийг Ирээдүйн өв сангаас Улсын төсөвт өглөг үүсгэх замаар барагдуулсан ба энэхүү зохицуулалтыг Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд тодорхой зааж хуульчилсан. Үүний дагуу Ирээдүйн өв сангийн хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх хугацаа буюу 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон Хүний хөгжил сангийн урьдын өглөгийг улсын төсөвт өглөгөөр бүртгэж, улсын төсвөөс барагдуулахаар зохицуулсан ба улсын төсөв тухайн шилжүүлэн авсан дүнгээр Ирээдүйн өв сангаас авах авлагаар бүртгэх арга хэмжээг авсан болно. Ирээдүйн өв сан нь Хүний хөгжил сангийн боловсронгуй хэлбэр байдлаар байгуулагдсан бөгөөд Хүний хөгжил санд хуримтлагдсан өр болох 1,071.9 тэрбум төгрөгийг 2017-2019 онуудад үе шаттайгаар Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан санд төвлөрөх орлогоос төлж, 2019 онд бүрэн барагдуулж дуусгасан ба энэ үеэс Ирээдүйн өв санд хуримтлал үүсгэж эхэлсэн.

2.12. “Эрдэнэс Тавантолгой” компаниас Ирээдүйн өв санд төвлөрүүлэх ёстой байсан 750 тэрбум төгрөгийг хэзээ, хэрхэн авах талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

Компанийн тухай хуулийн 46 дүгээр зүйлд ногдол ашиг төлөх асуудлыг зохицуулсан бөгөөд тус хуульд зааснаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилах, төлөх асуудлыг шийдвэрлэдэг. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт “Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс олгох ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр гаргана” гэж заасан тул ногдол ашигтай холбоотой мэдээллийг тухайн компани буюу төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс гаргуулна уу.



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2023.12.05 № 01/2206
танай 2023.11.24 -ны № ХЭГ/2566 -т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх асуулгын 2.12-т заасан “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас Ирээдүйн өв санд төвлөрүүлэх ногдол ашгийн төлбөр”-ийн талаар дараах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:


1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 сарын 17-ны өдрийн “Ногдол ашиг хуваарилах тухай” 09 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 (ер) төгрөгийн ногдол ашгийг иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хувьцаанд мөнгөн хөрөнгөөр, төрийн эзэмшлийн хувьцаанд компанийн эзэмшиж буй үнэт цаасаар ногдол ашиг хуваарилах шийдвэр гарсан. Энэхүү шийдвэрийн дагуу иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хувьцааны ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан олгосон. Харин төрийн өмчид ногдох ногдол ашгийн орлогыг компанийн эзэмшиж буй үнэт цаасаар хуваарилах шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар холбогдох дээд байгууллагаас чиглэл өгөөгүй бөгөөд компанийн балансад “Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг” дансанд 880.2 тэрбум төгрөг бүртгэгдсэн;

2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 220 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн өмчийн ногдол ашиг 880.2 тэрбум төгрөгөөс 117.2 тэрбум төгрөгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хуваарилахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасан байна. Мөн Сангийн сайдын 2022 оны 08 сарын 23-ны 01/5705 тоот албан бичгээр Засгийн газрын 220 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, 2022 оны 09 сарын 13-ны өдрийн 03/6253 тоот албан бичгээр Засгийн газрын 220 дугаар тогтоол нь Ирээдүйн өв сангийн тухай хуультай аливаа хэлбэрээр зөрчилдөхгүй байх тул тогтоолд тусгагдсан Хөгжлийн банкны хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг яаралтай хэрэгжүүлж ажиллах чиглэлийг тус тус ирүүлсэн.

Дээрх шийдвэрийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 09 сарын 26-ны өдрийн 32 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд санхүүжүүлсэн “Тавантолгой түлш” ХХК-ийн 763.0 тэрбум төгрөгийн санхүүжилт болон “Эрдэнэс Монгол” ХХК-д хуваарилсан 117.2 тэрбум төгрөгийг 2019 оны төрийн өмчийн ногдол ашгийн өглөгөөр барагдуулснаар бичилт хийж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг компанийн гүйцэтгэх удирдлагад даалгасан. Энэ шийдвэрээс “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх зээлийн өрийг ногдол ашгийн өрнөөс барагдуулахтай холбоотой шийдвэрийг хэрэгжүүлж “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас 2022 оны 09 сарын 29-ний өдөр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дансанд 117.2 тэрбум төгрөгийг шилжүүлсэн. Одоогоор компанийн санхүүгийн тайланд 763.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн өрийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Хүндэтгэсэн,

ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ



Ж.ГАНБАТ

0400004209